



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**

17060 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр,  
Утас: 6226-3051, Факс: (976) 7004-3479

Хо 19.01.08 № а/49  
таний \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА  
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Эрчим хүчний яаманд 2018 оны IV улиралд иргэд, аж ахуй нэгжээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлт тэдгээрийг шийдвэрлэсэн байдал, зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг хавсралт хүснэгтийн дагуу гаргаж хүргүүлэв.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт: Х хуудастай.



Ц.ДАВААСҮРЭН

008000053



## ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 07


Улаанбаатар хот

Эрчим хүчний сайдын зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд:

“2018 оны IV улиралд иргэд, аж ахуй нэгжээс Эрчим хүчний сайд, Эрчим хүчний яаманд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Төрийн захиргааны удирдлагын газрын дарга М.Баярмагнай танилцуулав.

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Өргөдөл гомдлын тайлан мэдээг тогтоосон хугацаанд нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар /М.Баярмагнай/-т даалгав.
2. Иргэд, аж ахуй нэгжээс Эрчим хүчний сайд, Эрчим хүчний яаманд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлыг чиг үүргийн дагуу хүлээж авсан албан тушаалтан эцэслэн шийдвэрлэж, иргэнд хуулийн хугацаанд хариуг өгөх, салбарын үйлдвэр компаниудад шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн өргөдөл гомдлын хариуг заавал авч, эргэх холбоотой ажиллахыг яамны бүх газар, хэлтсийн дарга наарт үүрэг болгов.” гэжээ



008000001

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМАНД 2018 ОНЫ IV УЛИРЛЫН  
БАЙДЛААР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ  
ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

Тус яам, иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх ажиллагааг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай“ Монгол Улсын хууль, бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж байна.

2018 оны IV улиралд иргэд, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал, зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээ, танилцуулгыг тогтоосон журам, хугацааны дотор гаргаж, Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулан дүгнэлт, шийдвэр гаргуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Тус яаманд 2018 оны IV улиралд 485 өргөдөл ирсэнээс хуулийн хугацаанд 463 өргөдлийг шийдвэрлэж бусад байгууллагад 62 иргэний өргөдлийг шилжүүлж шийдвэрлүүлсэн, 46 иргэний өргөдлийг хугацаа хэтрүүлж /сунгаж/ шийдвэрлэсэн, 22 өргөдөл хугацаа болоогүй /хяналтад/ байна. Нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн биелэлт 95.4% хэрэгжилттэй байна.

2018 оны IV улирлын байдлаар хүлээн авч, шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тайланг хавсралт 1,2,3-аар тус тус гарган хүргүүлж байна.

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**

.....тоот албан бичгийн  
нэгдүгээр хавсралт

Эрчим хүчний яаманд 2018 оны IV улирлын байдлаар иргэд, аж ахуй нэгжээс  
Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл,  
гомдол, санал хүсэлт

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс:				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Эрчим хүчний яам	485	464	17	4	0	0
Тайлбар: 11-11төвөөс шилжиж ирсэн санал хүсэлтийг тайландаа оруулаагүй болно. 2018 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар							

### ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

0/49.....тоот албан бичгийн  
хоёрдугаар хавсралт

Эрчим хүчний яаманд 2018 оны IV улиралд иргэд, аж ахуй нэгжээс Төрийн захиргааны байгууллага , албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлсэн	Хугацаа хэтрүүлж /сунгаж/ шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	Эрчим хүчний яам	485	463	62	46	22	95.4%

### ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

а/49....тоот албан бичгийн  
гуравдугаар хавсралт

### Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн агуулга

д/д	Байгууллагын нэр	Зонхиц байгаа асуудал /төо, нийт өргөдөл гомдолд эзлэх хувь/
1	Эрчим хүчний яам	<p>Нийт 485 өргөдлөөс: Хүсэлт – 406 / 83.7% Гомдол – 55 / 11.3% Санал – 24 / 4.9%</p> <ul style="list-style-type: none"><li>Түлш эрчим хүчний үйлдвэрлэлттэй холбоотой асуудлаар - 188 / 38.7%</li><li>Ажилд орох, гарах, чөлөө хүсэх, цалин хөл, тэтгэвэр тэтгэмж, зэрэг төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл баталгаатай холбоотой асуудлаар – 183 / 37.7%</li><li>Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа санхүүжилт төсөв хөрөнгөтэй холбоотой асуудлаар – 87 / 17.9%</li><li>Бусад асуудлаар – 27 / 5.5%</li></ul> <p>✓ Иргэдийн өмнө хамгийн их тулгамдаж буй агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд ЭХЯ-нд хамаарах ажил болох 123 халаалтын нам даралтын зуухыг үе шаттайгаар төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох ажлыг 2018 онд багтаан зохион байгуулахаар төлөвлөсөн. Холбогдох бүх ажлууд хийгдэж 127 халаалтын нам даралтын зуух төвлөрсөн дулаанд холбоод байна.</p> <p>✓ Мөн цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй байсан 2073 айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангасан.</p> <p>✓ Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор батлагдсан “Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчин тарифын хөнгөлөлт үзүүлэх журам” 2018 -2019 онд хэрэгжиж байна.</p> <p>✓ Сонгинохайрхан дүүргийн 11, 28 дугаар хорооны 11 байршилд шинээр 400 кВА-ийн /кило-вольт-ампер/ 5 ком дэд станц суурилуулсан, 250 кВА чадалтай 2 агаарын дэд станцыг 400 кВА чадалтай болгож хүчин чадлыг нэмэгдүүлсэн. 13149 метр 0.4 кВ-ын /кило-вольт/ агаарын шугам, 700 метр 10 кВ-ын кабель шугам, 25401 метр айл өрхийн оруулгын кабель татаж тус 2 хорооны нийт 858 айл өрхийг 4 кВт-ын чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэв.</p> <p>✓ 2018 оны IV улиралд иргэдээс салбарын үйлдвэр компаниудад ажилд ороход дэмжиж өгөхийг хүссэн өргөдлүүдийг салбарын үйлдвэр, компаниудад шилжүүлж шийдвэрлүүлсэн мөн ажилд орох гарах, чөлөө хүсэх, тусламж, тэтгэмж, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл баталгаатай холбоотой асуудлаар ирсэн өргөдлийг холбогдох хууль дүрэм журмын хүрээнд хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна.</p>

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ